

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭХ ХЭРЭГЦЭЭГ СУДАЛСАН НЬ

Г.Батцэнгэл, дэд профессор, Ч.Байгалмаа,
магистр, БоСС

Abstract: Purpose: The purpose of this study is to identify needs of preparing special education teachers at the Mongolian National University of Education and determine courses contents which needed be covered in special education teacher preparing program.

Background: More than fifty years have passed since establishing special education schools in Mongolia. The teachers of those schools were prepared mostly in Hungary and Russia. The program preparing of special education teachers was stopped during the transition period and after 1990. And the special education schools faced teacher shortage. There's a need to preparing special education teachers in own country.

Method: We conducted the study among the students from branch schools of MNUE such as School of Educational Studies, Teachers School and School of Pre-School Education. We did focus group discussion and interview with students from each school.

Result: In students' opinions, there's a need to start program to prepare special education teachers and the program must include modules on psychological, medical, pedagogical issues and participation of families and communities.

Key words: Special education, children with disabilities, special education teacher, defectologist

Судалгааны үндэслэл

Монгол Улсад тусгай хэрэгцээт боловсролын анхны байгууллага буюу хараа, сонсгол, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай анги, сургууль 1962-1964 онуудад байгуулагдаж даруй 50 гаруй жил болж байна.

Тусгай боловсролын “согог зүйч” мэргэжлийн багш нарыг хуучнаар ЗХУ, БНУАУ-д бэлтгэж ирсэн бөгөөд анхны согог зүйчид онд төгссөн. Энэ үеэс эхлэн дээрхи улсуудад хараа, сонсгол, хэл яриа, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн багш мэргэжлээр /олигофрено-педагог, логопед, тифлопедагог, сурдопедагог/ 1967-1985 онуудад нийт 113 гаруй үндэсний мэргэжилтнүүдийг бэлтгэжээ. Зах зээлийн нийгмийн шилжилтийн үе, 1993 оноос хойш гадаад оронд Төрөөс бодлогын шинжтэйгээр мэргэжилтэн бэлтгэх асуудал үндсэндээ зогссон байна.

Өнөөгийн байдлаар манай улсад хараа, сонсгол, оюуны хомстолтой хүүхдийн тусгай сургуулиудад цөөн тооны “согог зүйч” мэргэжлийн 23-60 насны 30-аад багш ажиллаж байгаа бөгөөд ойрын 1-3 жилийн дотор 15 багш тэтгэвэрт гарах мэдээ байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшийг шинээр бэлтгэх хэрэгцээ, сургалтын хэлбэр, төлөвлөгөө, агуулга, арга зүйг боловсруулах зорилгоор тус судалгааг 2013 оны 5-6 сард тусгай сургуулийн багш, МУБИС-ийн оюутнуудаас авсан болно.

Сэдвийн судлагдсан байдал

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэх хэрэгцээ шаардлагын талаар өмнө дараах судалгаануудад тэмдэглэн дурьдсан байна. Үүнд:

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох болон хөдөлмөрлөх эрх” сэдэвт судалгааг Мерси Кор олон улсын байгууллагаас 2010 онд зохион байгуулсан байна. Энэхүү судалгааны тайланд багшлах боловсон хүчний хүртээмж, ур чадварын талаар дараах дүгнэлтүүдийг хийсэн байна. “...тусгай сургуулиуд, сувиллын цэцэрлэгийн багш нараас бусад нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах ур чадвар эзэмшээгүй, дохионы хэл, брайль үсэг мэдэхгүй байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах наад захын чадварыг багшлах боловсон хүчинд тодорхой хэмжээгээр эзэмшүүлэх шаардлага-тай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарт зориулсан сургалт арга зүйн төв байгуулах шаардлага үүсч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах мэргэжлийн арга зүйчид ердийн ерөнхий боловсролын сургуульд төдийгүй, тусгай сургуулиудад ч хүрэлцэхгүй байна. (Мерси Кор, 2010, х.3. 25-26, 28)
- “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн

эрхийн байдал” судалгааны товч тайланд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургах талаар ахиц өөрчлөлт гарч байгаа нь харагдаж байна. Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарт арга зүйн тусламж үзүүлэх, урамшуулах ажлын үр дүнг тооцох оновчтой систем байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сургууль багшийн арга барилыг шинэчлэх (Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал, 2005, х. 2.3,7)

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарын хөдөлмөрийн онцлог, ажлын ачааллыг тогтоох үнэлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарын 63,1 хувь сургалтад хамрагдах шаардлагатай гэж үзсэн нь багш нарын мэргэжлийг системтэйгээр дээшлүүлэх нь чухал болохыг илтгэж байна (Г.Батцэнгэл, 2011).
- “Тусгай хэрэгцээт боловсролын нарийн мэргэшсэн багш бэлтгэх хэрэгцээ шаардлага” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд “Боловсролын тусгаарласан тогтолцооны хүрээнд хилийн чанадад Унгар, ОХУ-д 120-иод нарийн мэргэжлийн “согог зүйч” багш нарыг бэлтгэн ажиллуулж байсан. Одоо тэдний ихэнх нь тэтгэвэрт гарсан. (Одоо ажиллаж байгаа 39 согог зүйч багшийн 22 нь буюу 56,4% нь 50-аас дээш насныхан), 1992 оноос хойш гадаад оронд согог зүйч мэргэжлээр багш бэлтгэхээ больжээ. Энэ нь тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх ажил дутмаг, цаашид согог зүйч мэргэжлийн багшийн дутагдалд орж байгааг харуулж байна. (Ц.Баттуяа, 2013, х.5. 27)

Судалгааны зорилго

МУБИС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшийн ангийг шинээр нээх хэрэгцээ, сургалтын төлөвлөгөө, агуулга тодорхойлох, “Тусгай хэрэгцээт боловсрол” хичээлийн хөтөлбөрийн өнөөгийн байдалд үнэлгээ өгөх зорилготой. Энэхүү судалгааг 2013 оны 5-6-р сард явуулсан болно.

Судалгааны хамрах хүрээ

МУБИС-ийн Багшийн сургууль /БС/, Боловсрол Судлалын Сургууль /БоСС/, Сургуулийн Өмнөх Боловсролын Сургуулийн /СӨБС/ оюутнууд

Судалгааны зорилт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаарх онолын үзэл баримтлал, дэлхий нийтийн чиг хандлагад дүн шинжилгээ хийх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэх хэрэгцээг тодруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэх талаар зөвлөмж боловсруулах


Судалгааны арга

- Баримт бичгийн судалгаа
- Асуулга
- Бүлгийн, ганцаарчилсан ярилцлага
- Кейс анализ
- Математик статистик боловсруулалт


Судалгааны үр дүн

Судалгаанд МУБИС-ийн Багшийн сургууль, Боловсрол Судлалын Сургууль, Сургуулийн Өмнөх Боловсролын Сургуулийн нийт 18-49 насны 198 оюутан хамрагдсан болно. Судалгаанд оролцогчдын хүйсийн байдлыг авч үзвэл эрэгтэй 5,9%, эмэгтэй 94,1%-ийг тус тус эзэлж байна.

Оюутнуудын суралцаж буй сургуулийн байдлыг авч үзвэл, БС-29,2%, БоСС-49,5%, СӨБС-21,3% -тай тус тус байна.




Судалгаанд оролцсон оюутнуудын суралцаж буй мэргэжлийн байдлыг авч үзвэл, бага ангийн багш – 29,2%, нийгмийн ажилтан-23,3%, сэтгэл судлаач-26,2%, цэцэрлэгийн багшийн арга зүйч 21,3% тус тус байна.



Суралцаж буй курсын байдлыг авч үзвэл

- хоёрдугаар курс-3,5%,
- гуравдугаар курс-44,6%,
- дөрөвдүгээр курс-45,5%,
- бага ангийн багшаар ажиллаж байгаа багш нарын “А” анги-6% тус тус эзэлж байна.

Тусгай хэрэгцээтийн хичээлийг хэдэн кредит судалсан байдал



Судалж байгаа хичээлийн байдал

МУБИС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэх ажлын хүрээнд шинэ хичээлийн хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн агуулгад лекц, семинарын цаг нэмж оруулах, сонгоны хичээл хэлбэрээр оруулах, хөтөлбөрт агуулгын шинэчлэл хийх замаар 2003 онд ЭМ, НХХЯ, БСШУЯ-ны хамтарсан “Тэгш хамруулан сургах хөтөлбөр” батлагдсантай холбоотойгоор нэлээд эрчимтэй хийгдэж ирсэн байна. Энэхүү өөрчлөлт шинэчлэлийн байдлыг салбар сургуулийн байдлаар авч үзвэл

Дээрх хүснэгтээс харахад МУБИС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт, тэдэнтэй ажиллах арга зүйн талаар оюутнууд голлон 3 курст 5 төрлийн хичээлээр 1-4 кредит агуулгын хүрээнд мэдлэг, чадвар хандлагын төлөвшилийг олж авч байна. БоСС-ийн БСАЗ тэнхим “Багш мэргэжлийн үндэс” хичээлээр 2 цагийн семинарын хичээлээр тэгш хамруулан сургах боловсрол агуулгыг судлахаар тусгасан байна.

№	Салбар сургууль, тэнхим	Хичээлийн нэр	Хэддүгээр курст	Кредит	Хэдэн оноос	
1.	БоСС Сэтгэл судлалын тэнхим	“Тусгай сэтгэл судлал”	3-р курст, 2-р семестр	3	1995	
2.	БоСС Нийгмийн ажлын тэнхим	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах нийгмийн ажлын арга зүй	3-р курс семестр	2-р	1	1997
3.	Багшийн сургууль	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган хүмүүжүүлэх зүй”	3-р курс семестр	1-р	2	1993
4.	Багшийн сургууль	“Хэл засал, сэтгэл засал” сонгон	4-р курс семестр	1,2-р	4	2012
5.	СӨБСургууль	Тусгай хэрэгцээт боловсрол	3-р курст, 2-р семестр	2	2010	

1993 оноос МУБИС-ийн Багшийн сургуульд “согог зүйч” багш бэлтгэж, бага боловсролын мэргэжлийн багшийн ангид “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган хүмүүжүүлэх зүй”, “хэл засал, сэтгэл засал” чиглэлээр сонгоны анги хичээллэдэг болж, их дээд боловсролын тогтолцоонд согог судлалын шинжлэх ухаан өөрийн байр суурийг эзэлж ирсэн байна. (6.16.)

Дээрх хичээлүүдээр судалсан зүйлийнхээ агуулгын талаар товч бичнэ үү? гэсэн нээлттэй асуултад өгсөн хариултыг багцалбал:

- Тусгай боловсролын дэлхийн болон манай улсын хөгжлийн чиг хандлага
- Тэгш хармуулан сургах боловсролын талаар
- Хөгжлийн бэрхшээлийн төрөл
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог

- Хөгжлийн бэрхшээл үүсэж буй шалтгаан
- Ажиллах арга зүй

Оюутнууд дээрх судалж буй хичээлүүдийг

- Маш сонирхолтой гэж- 25,8%
- Сонирхолтой гэж- 51%
- Дунд зэрэг – 17,7%
- Тийм ч сонирхолтой биш гэж 13,6% үзсэн байна.

Нийт судалгаанд оролцогчдын 76,8% сонирхолтой гэж үзжээ.

- МУБИС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшийн ангийг нээх шаардлагатай гэж 97% нь үзсэн байна.
- Хэрэв тус сургуульд шинээр анги нээвэл 54,5% нь суралцана, 38,9% нь сайн мэдэхгүй

буюу эргэлзсэн хариулт өгсөн байна.

- Багш бэлтгэдэг Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн хүүхэдтэй ажиллах арга зүйн талын агуулгыг тусгах нь хэрэгтэй юу? гэсэн асуултад, хэрэгтэй гэж 86,4%,

хэрэггүй гэж 3,5%, мэдэхгүй гэж 10,1% нь хариулсан байна.

- Сургалтын агуулгыг ямар чиглэлээр явуулах нь зүйтэй вэ? гэсэн асуултанд өгсөн хариултыг багцалбал:

№	Сургалтын агуулгын чиглэлүүд	Хувь
1.	ХБ-тэй хүүхэдтэй харилцах ур чадвар	69,4%
2.	Сурах чадварын онцлогт тохируулан сурах арга барил	67,7%
3.	ХБХ-ийн сурах чадварыг тодорхойлох	56%
4.	ХБХ-ийн сэтгэл зүйн онцлог	57,5%
5.	Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх аргачлал	46,3%
6.	Анги хамт олондоо дасан зохицоход нь туслах ур чадвар	58,8%
7.	Хичээлийн тусгай хөтөлбөр боловсруулах	58,4%
8.	Танхимаас гадуурх сургалтын үйл ажиллагааг төлөвлөх	38%
9.	Бусад багш мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах арга зүй	43,4%
10.	Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах арга барил	61,7%
11.	ХБХ-ийг хөгжүүлэх арга зүй	66,5%
12.	Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн тусламж үзүүлэх	50,3%
13.	Хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлтийг үнэлэх арга зүй	53,4%
14.	Хүүхэдтэй ганцаарчлан ажиллах хөтөлбөр боловсруулах	57,4%

ДҮГНЭЛТ, САНАЛ

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшийг бэлтгэх ажлыг МУБИС голлон удирдаж, сургалтын хөтөлбөр шинээр боловсруулах, анги нээх, агуулгын шинэчлэл, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж ирсэн байна.

Дээрх хариултаас харахад бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа дараах агуулгыг олгоход түлхүү анхаарах шаардлагатай нь харагдаж байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохируулан харилцах харилцааны ур чадвар эзэмшүүлэх
- Сургах, хөгжүүлэх арга зүй
- Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй
- Хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүрийн талаар тойм ойлголт өгөх
- Ганцаарчлан ажиллах хөтөлбөр боловсруулах
- Судлах үнэлэх судалгааны арга зүй

Энэ бүгдээс дүгнэж үзэхэд

- Бэрхшээлийн төрөл, гэмтэл согогийн талаар мэдлэг олгох хичээл /согогийн онцлог/
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сэтгэл судлал /сэтгэл зүйн онцлог/
- Чадвар алдалтанд тохируулан, нийгмийн дасан зохицолд нь туслах нөхөн сэргээх, заслын бүлэг хичээлүүд баймаар байна. /хэл засал, хөдөлгөөн засал, ахуй засал, боловсролын сэргээн засал, хөдөлмөр засал, сэтгэл засал/

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Их хурал. (2013). Бага дунд боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай. Улаанбаатар.

Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгааны товч тайлан. (2005). Улаанбаатар.

Мерси Кор. (2010). “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох болон хөдөлмөрлөх эрх”. Улаанбаатар.

Батцэнгэл, Г. (2012). “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарын хөдөлмөрийн онцлог, ажлын ачааллыг тогтоох үнэлэх нь”. Оюуны хөтөч. Улаанбаатар.

Баттуяа, Ц. (2013). “Тусгай хэрэгцээт боловсролын нарийн мэргэшсэн багш бэлтгэх хэрэгцээ шаардлага”. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй сэргээн засах тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх нь сэдэвт ЭШХ, илтгэлүүдийн эмхэтгэл. Улаанбаатар.

Цэвээнлхазал, Я. (2013). “Монгол улсад тусгай хэрэгцээт боловсрол хөгжиж ирсэн түүхэн сургамж, үе шат”. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй сэргээн засах тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх нь сэдэвт ЭШХ, илтгэлүүдийн эмхэтгэл. Улаанбаатар.

Батцэнгэл, Г., Туяа, Б., Одгэрэл, Д., Гэрэлтуяа, Ц. (2012). “Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийг судлах арга зүйн зөвлөмж” Улаанбаатар.

Философи, эрх зүйн боловсрол, 2014, №8

ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ТӨЛӨВШИЛ БА ХЭРЭГЦЭЭ

Т.Цэндсүрэн, дэд проф, Ч.Байгалмаа,
Оюут-Эрдэнэ, М.Нямдорж, Х.Өлзийтунгалаг,
О.Жаргалсайхан, магистр. МУБИС

Abstract: The purpose of this research is to identify a social development of adolescents. In this research, the social development characteristics include self-esteem, social relationships (with peer, family and others), autonomy, communication with others, identity, social role and etc.

A cross-sectional study used individualized data for adolescents 10-19 years of age from the Ulaanbaatar (capital city of Mongolia), Arkhangai, Khovd, Dornod and Darkhan-Uul province (N = 600 adolescents). The following tests used in this research: Hare self-esteem scale, Rosenberg self-esteem scale, Self-concept scale for children, Index of family relations. We also conducted focus group discussion and interview with parents' and secondary school teachers' representatives from each sites.

The self-esteem is high among the adolescents who participated in the study. There were observed laziness, irresponsibility, lack of social skills among them. Independence level and social status of them was in average level.

Түлхүүр үг: Өсвөр нас, нийгмийн хөгжил, өөртөө итгэх итгэл, харилцаа, өөрийн адилтгал, бие даасан байдал

Удиртгал

Өнөөгийн нийгэмд өв тэгш хөгжил төлөвшилтэй ирээдүйн иргэдийг бий болгохын тулд өсвөр үеийнхний хөгжлийг тал бүрээс нь судлан, системтэй арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал асуудал болж байна. Тиймээс бид /Нийгмийн ажил арга зүйн тэнхим/ энэ үйл хэрэгт тодорхой хувь нэмэр оруулах үүднээс өсвөр үеийнхний нийгмийн хөгжил, төлөвшлийн өнөөгийн байдлыг судалж, хэрэгцээг тодорхойлох судалгааг хийлээ.

Судалгааны зорилго: Өсвөр насны хүүхдийн нийгмийн хөгжил, төлөвшлийн өнөөгийн байдлыг судалж, түүнтэй уялдуулан хэрэгцээг тодорхойлох

Судалгааны арга зүй: Тоон болон чанарын судалгааны аргуудаар мэдээллийг цуглуулж, боловсруулалт, дүн шинжилгээ хийлээ. Тухайлбал, Улаанбаатар хот болон Дархан-Уул, Архангай, Ховд, Дорнод аймгуудаас 10-19 насны нийт 600 өсвөр үеийнхнээс урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу мэдээлэл цуглуулж, SPSS 20 программ дээр нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийсэн. Мөн судалгаа явуулсан аймаг, хот тус бүрт эцэг эх, багш, мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийж, чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Өсвөр үеийнхний нийгмийн хөгжлийн талаарх онолын үзэл баримтлал

НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан болон ДЭМБ зэрэг олон улсын байгууллагууд 10 – 19 насныхныг өсвөр үеийнхэн гэж тодорхойлсон байдаг. Зарим эрдэмтэд өсвөр үеийнхний хөгжлийн асуудлыг бие бялдрын, танин мэдэхүйн, сэтгэц-нийгэмшихүйн гэсэн үндсэн 3 хүрээнд авч үздэг бол зарим нь эдгээрийг нарийвчлан бие бялдрын, нийгмийн буюу нийгэмшихүйн, танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн, ёс суртахууны гэсэн 5 хүрээнд авч үзсэн байдаг.

Нийгэм, сэтгэл зүйн үүднээс Эриксон өсвөр үеийг өөрийн гэсэн өвөрмөц шинж чанар бүрдэх, нийгэмд эзлэх байр суурь болон өөрийн үүргээ эрж олох эрэл хайгуулын үе гэж тодорхойлсон байна. (Мягмар, О 2000) Сэтгэл судлал болон боловсролын салбарын эрдэмтэд өсвөр үеийнхний нийгэмшихүйн хөгжлийн хүрээнд өөртөө итгэх итгэл, өөрийн үнэлэмж; үе тэнгийгнхэн, гэр бүл, хамт олонтой харилцах харилцаа; нийгмийн үүрэг хариуцлага, бие даасан байдал зэргийг багтаажээ.

Нийгэмшихүйн хөгжлийн хувьд өсвөр насныханд дараах онцлогууд илэрдэг. Үүнд: эрх чөлөөтэй, хараат бус байх; бусдад өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийн тулд янз бүрийн үйлдэл хийх, тухайлбал, эрсдэлтэй зүйл хүртэл хийх; олон зүйлийг сонирхох; өөрийнхөө үзэл бодлыг зөвтгөх; өөрийгөө том хүн болсон гэж үзэх учраас

өөрөө л шийдвэр гаргах ёстой гэж бодох; гаргасан шийдвэрээ өөрөө хэрэгжүүлж, хариуцлагаа өөрөө хүлээнэ гэж бодох; найз нөхдөөс нь илүү тэднийг ойлгож хүндлэх хүн байхгүй хэмээн үзэх тул үе тэнгийнхэнтэйгээ ихэнх цагийг өнгөрүүлэх, тэдэнд илүүтэй итгэж найдах; найз нөхдийн харилцааг нэн тэргүүнд чухалчилдаг байна.

Энэ насанд сургалт, хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад нийгэм хамт олон, бүлгийн үнэт зүйл, хэм хэмжээнд захирагдах, өөрийн үнэлгээ, өөртөө дүн шинжилгээ хийх, шүүмжлэлт сэтгэлгээ, шийдвэр гаргах, үүрэг хариуцлагаа ухамсарлах, харилцаа холбоо тогтоох зэрэг бие хүний нийгэм сэтгэлзүйн суурь чадвар дадлууд хөгжин төлөвшдөг. Тиймээс өсвөр үеийнхний нийгэмшихүйн хөгжлийн асуудлыг бусад хүрээний нэгэн адил чухлаар авч үзэх шаардлагатай юм.


Өсвөр үеийнхний нийгмийн хөгжил, төлөвшлийн өнөөгийн байдал

Өөрийн үнэлэмж: Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний өөрийн үнэлэмж нэлээд дээгүүр байгаа хэдий ч дунд зэрэг болон тааруухан гэж өөрийгөө үнэлсэн хүүхдүүд тодорхой хувийг эзэлж байлаа.

Өсвөр насныхны хувьд өөрийн үнэлэмж өндөр байх нь хичээл сурлага, бусадтай харилцах харилцаа, дасан зохицох чадвар, ирээдүйн амьдралд эерэг нөлөө үзүүлнэ.

Зураг 1

Өсвөр үеийнхний өөрийгөө үнэлэх үнэлэмж



Өсвөр үеийнхний өөртөө итгэх итгэл, өөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхийн тулд эцэг эх, багш, найз нөхөд, бусад хүмүүс юу хийх хэрэгтэй талаар судалж үзэхэд эцэг эхчүүд хүүхэдтэйгээ

Хүснэгт 1

Өсвөр үеийнхний бусдын дунд эзлэх байр суурь

№	Байр суурь	Сайн	Дунд	Тааруухан
1	Өсвөр үеийнхний үе тэнгийнхнийхээ дунд эзлэх байр суурь	46.1	52.4	1.5
2	Өсвөр үеийнхний гэр бүл дэх байр суурь	76.5	21	2.6
3	Сургууль дээр эзлэх байр суурь	61.3	37.9	0.9
4	Өсвөр үеийнхний бусдын дунд эзлэх ерөнхий байр суурь	60.5	38	1.5

ярилцаж, тэднийг сонсдог зөвлөгөө өгдөг, хайр халамжаар дутаахгүй сайн хүмүүжүүлдэг, хүүхдээ магтаж урамшуулдаг байх, харин найз нөхдийн зүгээс бие биендээ туслах, сайн үлгэр дуурайлал үзүүлэх, чин сэтгэлээсээ ярилцаж ойлгодог байх, бие биенийхээ итгэлийг даадаг байх, багш нарын зүгээс өсвөр насны хүүхдүүдэд зөвлөгөө өгдөг байх, ганцаарчлан уулзаж, тэдний асуудлыг ойлгодог байх, адил тэгш хандах, урмын үг хэлж урамшуулдаг байх хэрэгтэй гэж судалгаанд хамрагдсан хүүхэд, өсвөр үеийнхэн үзсэн байна.

Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний багагүй хувь нь (39 хувь) өөрсдийгөө үргэлж бардам гэж үзсэн байв. Энэ нь 2 талтай ойлголт бөгөөд нэг талаас өөртөө итгэлтэй байдлаа илэрхийлсэн байж болох талтай нөгөө талаас хэт онгироо, биеэ тоосон хандлагыг илэрхийлэх сөрөг үзүүлэлт юм. Мөн тэдний дунд уурлаж бухимдалгүй асуудлыг шийдвэрлэх, зохицуулах чадвар дутмаг, атаархуу зан ажиглагдаж байлаа.

Хэдийгээр өсвөр үеийнхний тэн хагасаас илүү хувь нь өөрсдийгөө үргэлж хариуцлагатай, хамтач, ажилсаг гэж үнэлсэн ч багагүй хувь нь ямагт ийм байж чаддаггүй болохоо илэрхийлжээ. Залхуу, зөрүүд, ичимхий гэсэн сөрөг шинжүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд үргэлж залхуурдаг гэсэн хариулт нэлээд их хувийг (63.3) эзэлж, огт залхуурдаггүй гэсэн хувь дөнгөж 5.6 хувийг эзэлж байлаа. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 58 орчим хувь нь үргэлж санаачлагатай байдаг гэж үзжээ. Өсвөр үеийнхэн нийгэмшихүйн хөгжлийн хувьд олон зүйлийг сонирхож, санаачлан хийж турших хүсэл эрмэлзэлтэй байдаг боловч судалгааны үр дүн үүнтэй нийцэхгүй байгаа нь монголын өсвөр үеийнхний нэлээдгүй хувь нь залхуу хойрго, бүтээлч биш, санаачлагагүй болж байгааг илэрхийлж байна.

Өсвөр үеийнхний бусдын дунд эзлэх байр суурь: Бруке Р. Харегийн сорилыг ашиглан өсвөр насны хүүхдийн үе тэнгийнхнийхээ дунд болон гэр бүл, сургуулийн хүрээнд эзлэх байр суурийг тодорхойлсон. Энэхүү сорилын үр дүнг авч үзвэл сайн гэсэн хувь хэдийгээр 50-иас дээш (хүснэгт 1) байгаа ч нийтлэг хүрээнд авч үзвэл дундаж гэсэн болон тааруухан гэж үнэлэгдсэн өсвөр үеийнхний байр суурийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг гэр бүл, найз нөхөд, сургуулийн орчинд хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Бусдын дунд эзлэх байр суурийг харьцуулан үзвэл өсвөр үеийнхний дийлэнх нь гэр бүлдээ эзэлдэг байр суурь сайн, мөн тааруухан гэсэн 2 үзүүлэлт бусдаасаа илүү хувийг эзэлж байна (хүснэгт 1). Энэ нь зарим өсвөр үеийнхэн гэр бүлдээ тодорхой байр суурь эзэлдэггүй буюу үл тоомсорлогддог байж болзошгүйг илэрхийлж байна. Энэ нь эцэг эхчүүд хүүхдэдээ анхаарал халамж тавихаасаа илүүтэй ажил төрөл бусад асуудлуудад анхаарах болсон нийгмийн үзэгдэлтэй ч холбоотой байж болох юм. Тийм ч учраас энэ асуудлыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай.

Өсвөр үеийнхний харилцаа: Өсвөр үеийнхэн үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааг илүүтэй чухалчилдаг болох нь судалгааны үр дүнгээс

Хүснэгт 2

Өсвөр үеийнхний харилцаа

№	Харилцаа	Маш сайн	Сайн	Дунд	Тааруухан
1	Өсвөр үеийнхэнтэйгээ харилцах харилцаа	47.3	45.5	7.2	-
2	Эцэг эхтэйгээ харилцах харилцаа	1.8	52.7	41.8	3.7

Өсвөр үеийнхний нийгмийн үүрэг хариуцлага, бие даасан байдал

Нийгмийн үүрэг, хариуцлага, бие даасан байдлыг нь илрүүлэх зорилгоор судалгаанд оролцогчдын хичээл сурлага, ажил хөдөлмөрт хандах хандлага, чөлөөт цагаа өнгөрүүлж буй байдал, хүсэл мөрөөдөл амьдралын зорилго, хариуцлага хүлээх чадвар, ёс суртахууны төлөвшил хийгээд тэдний нийгмийн идэвх оролцоо, хэрэгцээ шаардлага зэргийг судлан шинжилсэн. Өсвөр насныхны бие даах чадварын тал дээр эцэг эх болон багш мэргэжилтнүүдийн бодол санаа, байр суурь нэлээд зөрүүтэй байгааг тэдний хариултуудаас харж болно. Эцэг, эхчүүд болоод багш, мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар өсвөр насны хүүхдүүдийн ихэнх нь хараахан амьдралын зорилгоо нарийн тодорхойлж чадаагүй байдаг ба зорилго гэхээсээ илүүтэй мөрөөдлийн шинжтэй байх нь түгээмэл ажиглагддаг байна. Эцэг эхчүүдийн хувьд өөрсдийн хүүхдүүдийг харьцангуй бие даасан хэн нэгнээс хамааралгүйгээр аливаа зүйлийг ганцаарчлан шийдвэрлэж гүйцэтгэх чадвартай хэмээн үзэж байхад багш нарын дийлэнх хувь нь өнөөдрийн өсвөр насныхан бие даах чадварын хувьд ихээхэн учир дутагдалтай хэмээн үзжээ. Цаашилбал тэднийг гаднаас нь өнгөцхөн харвал бие даасан мэт ойлгогддог ч, үнэн хэрэгтээ хэн

харагдаж байлаа (хүснэгт 1). Энэ нь хэдийгээр тэдний насны онцлогтой холбоотой боловч тэд өөртөө тохиолдсон асуудал, эргэлзэж тээнэгэлзсэн зүйлс, шийдвэр гаргах шаардлагатай нөхцөл байдлын талаар үе тэнгийнхэнтэйгээ ярилцаж зөвшилцөж, улмаар эрсдэлтэй алхам хийхэд хүргэж болзошгүй. Тиймээс эцэг эхчүүд өсвөр насны хүүхдүүдтэйгээ дотно харилцаж, тэднийг зөв чиглүүлэх үүргээ оновчтой арга замаар хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Ярилцлагаас үзэхэд зарим эцэг эхчүүдийн хувьд хүүхдүүдтэйгээ нээлттэй чөлөөтэй харилцахаас илүүтэй тэднийг бага балчир жаахан хүүхэд мэтээр төсөөлөн хандах явдал ч цөөнгүй гардаг байна.

нэгнийг аялдан дагалдсан, дуурайх шинж байдал ажиглагддаг гэсэн хариултыг өгчээ.

Өсвөр насныхны дунд хэдийгээр өөрт оногдсон ажлаа сайн хийж гүйцэтгэдэггүй хэсэг нь дийлэнх хувийг эзлээгүй ч гэсэн хүссэн зүйлдээ хүрэхийн тулд хичээж хүчин чармайлт гаргадаг болохыг судалгааны үзүүлэлтүүд харуулж байсан. Өсвөр үеийнхэнд оногдсон ажлаа тодорхой хэмжээгээр сайн гүйцэтгэхэд нь туслах, хариуцлагатай байх чадварыг эзэмшүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний хувьд тэдний өөрийн үнэлэмж, өөрийгөө тодорхойлж буй байдал нэлээд өндөр түвшинд байна. Гэвч багш, эцэг эхийн зүгээс өсвөр үеийнхний өөрийн үнэлэмжийг өөрсдөөс нь арай доогуур түвшинд үнэлж байна.

Өсвөр үеийнхний нийгэмшихүйн хөгжлийг илэрхийлэх бусад үзүүлэлтүүд тухайлбал, бие даасан байдал, чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг, гэр бүл найз нөхдийн харилцаа, бусдын дунд эзлэх байр суурь зэргийг дундаж түвшинд гэж дүгнэж болохоор байна. Энэ байдал нь тэднийг ирээдүйд бүтээлч, бие даасан, нийгмийн идэвхтэй нэгэн гишүүн болоход эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдийн дэмжлэг тусалцаа чухал

болохыг харуулж байна.

Нөгөөтэйгүүр өсвөр үеийнхний хүмүүжил, төлөвшил төдийлөн хангалттай бус байна. Энэ нь тэднийг хүмүүжүүлж, төлөвшүүлэх, хөгжүүлэхэд эцэг эх, багш нар, сургалтын байгууллага болон бусад холбогдох байгууллага, олон нийт анхаарч ажиллах хэрэгцээ шаардлага байгааг илэрхийлж байна.

Санал зөвлөмж

Өсвөр үеийнхэн ихэнх цагийг сургууль дээр өнгөрүүлдэг учраас сургалтын байгууллага тэдэнд болон тэдний эцэг эх, олон нийтэд нийгэмшихүйн хөгжлийг зөв чиглүүлэх, дэмжих талаар тодорхой хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, эцэг эх, олон нийтэд зорилусан сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, эсвэл сургалтаас гадуурх үйл ажиллагаагаар суралцагчдыг хэрхэн хөгжүүлэх, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх гэх мэт.

Мөн багшийн үйл ажиллагаа нь өсвөр үеийнхний өөрийн үнэлэмж, бие даасан байдал, үүрэг хариуцлага ухамсарладаг болоход тодорхой хувь нэмэр оруулж байдаг учраас үүнтэй холбоотойгоор дараах зүйлсийг анхаарах нь чухал юм. Суралцагчдын дүнг нийтэд бус, зөвхөн хувь хүнд өөрт нь мэдээлэх, дасгал даалгаврыг дахин гүйцэтгэж дүнгээ ахиулах боломжийг олгох, цөөхөн хэдхэн суралцагч өндөр оноо авах зүйлсээс зайлсхийх, хичээлийн явцад бүлгээр ажиллуулахдаа суралцагчдын чадвараар нь ангилж бүлэг бүрдүүлэхгүй байх, бүх суралцагч амжилт гаргах боломж бүхий хувь хүнд нь тохирсон даалгавар өгч гүйцэтгүүлэх, суралцагчдыг бие биетэй нь өрсөлдүүлэх бус харин тухайн суралцагчийн өмнөх түвшинг сайжруулахад анхаарах хэрэгтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Батдэлгэр, Ж., Туяа, Б., Эрдэнэчулуун, Д., Оюунцэцэг, Б. (2014). *Хүний хөгжлийн сэтгэлзүй*. Улаанбаатар:

Ичинхорлоо, Ш. (2014). *Хүүхдийн хөгжил* (5 дахь хэвлэл). Улаанбаатар: Хөх монгол принтинг.

Мягмар, О. (2000). *Хүний хөгжлийн сэтгэлзүйн цуврал лекцүүд*. Улаанбаатар.

Режеп Шүкрү Апухан. *Бид хүүхдээ залуу нас ба амьдралд бэлдэж байна*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Грэйс Крайг. (2000). *Психология развития* (7-е международное издание). Санкт-Петербург: Петер.

Wendy L.Dunn., Grace J.Craig. (2013). *Understanding human development* (3rd ed.). Upper Saddle River, NJ: Pearson.

Нийгмийн ажлын практик. 2005 №1